

## ЭМЭГТЭЙЧҮҮД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХӨД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ



FACTORS AFFECTING WOMEN TO EXPERIENCE DOMESTIC VIOLENCE

**Л.Нямгэрэл\***

Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн докторант

Nyamgerel L, Ph.D Candidate in Law, University of Internal Affairs

**Ч.Нямсүрэн**

Доктор, профессор

Nyamsuren Ch, Prof, Ph.D

МОНГОЛ УУДААЛСАН ТАДЫН МАСЛООЛСОН ТӨВИЙН  
УДААНЫ САХИУЛАХАЙ

\*Хариуцлагатай зохиогч: nyamgerel@mojha.gov.mn

**Хураангуй:** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оноос хэрэгжиж эхэлснээс хойш гэр бүлийн хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо, эрх зүй бурдсэн.

Гэвч хууль, тогтоомжийн уялдаа холбоо хангалтгүй, давхардалтай, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын чиг үүрэг ерөнхий, салангид зохицуулагдсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэж буй хариуцлага, албадлагын арга хэмжээ оновчтой бус, хохирогчид үйлчилгээ үзүүлэх чанар, хүртээмж сул, хохирогчид үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын санхүүжилтийн талаар тодорхой тусгаагүй зэрэг тулгамдсан асуудал байсаар байна.

Иймд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг судлах замаар энэ төрлийн гэмт хэрэгт өртөж буй эмэгтэйчүүдийн зан үйл, хэв шинжийг тогтоож, хэрэгт хохирох явдал, гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгаан, гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх ажлыг виктимологийн шинжлэх ухааны үүднээс шинээр тодорхойлох шаардлагатай байна.

**Abstract:** Since the revision of the Law on Combating Domestic Violence came into force in 2017, a national system for combating and preventing this type of crime has been formed and the legal framework has improved.

However, the coordination of laws and regulations is insufficient, there is duplication, the functions of the organizations obligated by law are general and separately regulated, the responsibility and coercive measures imposed on perpetrators of domestic violence are not optimal, the quality and accessibility of services to victims is weak, and there is no clarity about the financing of organizations that provide services to victims. There are still being the problems which are waiting their solutions.

Therefore, by studying the victims of domestic violence, we will determine the behavior and patterns of women who are victims of this type of crime, the risk of being victimized, the factors affecting it, the causes, and the prevention of victimization from the perspective of victimology. Thus, it is needed to redefine more concretely.

**Түлхүүр үгс:** Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн шалтгаан, хүчин зүйл.

**Keywords:** Gender based violence, domestic violence, causes and factors of violence

### Үндсэн хэсэг

Гэмт хэргийн виктимологийн шинжлэх ухаан шинэ тутам хөгжиж байгаа өнөө үед гэмт хэрэгт хохирох явдал

(victimization), гэмт хэрэгт хохирох эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгаан, хохирогч-этгээд (хувь хүн, байгууллага, төр, нийгэм), гэмт хэрэгт



МОНГОЛ УЛСЫН ХУЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙГДЭЭГҮҮД

хохирохоос урьдчилан сэргийлэх ажлыг виктимологийн шинжлэх ухааны үүднээс шинээр тодорхойлж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх нийгэм-улс төр, эрх зүйн хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

Хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн гэмт хэргийн хохирогч судлалын онол, арга зүй, мөн гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгт хохирох эрсдэл, хохирох явдал (*victimization*), түүнээс урьдчилан сэргийлэх, хохирох явдлын үр дагаврыг арилгах асуудлыг дэлхийн улс орнуудын виктимологийн шинжлэх ухаан, түүний практик ололт амжилтын тухай мэдлэг, мэдээлэлд үндэслэн криминологийн болон эрүүгийн эрх зүйн онолын хандлага талаас нь авч үзсэн “Гэмт хэргийн виктимологи” нэг сэдэвт бүтээл (Ч.Нямсүрэн, 2005) туурвисан нь манай улс дахь хохирогч судлалын чиглэлээр бичигдсэн анхны нэг сэдэвт бүтээл болжээ.

Шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан Монголын төр, эрх зүй сэтгүүлийн 1996 оны №2 дугаарт нийтлүүлсэн Хохирогч судлал, түүнийг нөлөөллөөс хамгаалах асуудал өгүүлэлдээ “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн хүчин зүйлүүдийн дотор хохирогч ямар үүрэг гүйцэтгэснийг тогтоох зайлшгүй шаардлагатай. Учир нь гэмт халдлагад өртөгдсөн хохирогчийн хууль бус үйл ажиллагаа, гэмт зан төлөв зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан, шийдвэрлэх нөхцөл болдог. Тийм ч учраас хохирогч судлал нь орчин үед криминологийн шинжлэх ухааны шинэ чиглэл болон хөгжих боллоо” хэмээн бичжээ (С.Жанцан, 1996). Энэ нь бидний судалгааны ажилд авч үзэж буй хохирогчийн зан үйл, хэв маягийг тодорхойлох зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш өнөөг хүртэл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нэг удаа хийгдэж, хуулийн хийдэл, давхардлыг нь арилгах, хэрэгжихгүй байгаа

шалтгааныг нь тодорхойлж засах шаардлагатай асуудлуудаар 20 гаруй судалгааны ажил хийгджээ.

Судалгааны ажлуудыг тоймлон авч узвэл хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт, хүчирхийллийн хохирогчийн талаарх хүн амын ойлголт, хандлага, хүн ам зүйн байдлын талаарх судалгаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны талаарх судалгаа, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ судалгаа голлож байна (ГХУСАЗЗАА, Хөгжлийн эрх зүйн төв ТББ, 2023).

Хэдийгээр судалгааны ажлуудад гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийн талаар авч үзсэн ч эмэгтэйчүүд яагаад гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа, ямар хүчин зүйл нөлөөлж байгааг гүнзгийрүүлсэн судалгаа хийгдээгүй байна.

Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийллийн чиглэлээр хийгдсэн хамгийн том судалгаа болох “Жендерт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаа”-гаар дараах гол үр дүн гарсан байdag (Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан, 2017). Тухайлбал,

1. Эмэгтэйчүүдийн 29.7 хувь нь хамтрагчаас, 17.3 хувь нь бусдын зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байdag. Эндээс харахад эмэгтэйчүүд хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байна;

2. Хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 14.0 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Энэ нь Ази, номхон далайн бүсийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна;

3. Хэнтий, Дархан-Уул, Өмнөговь, Улаанбаатар, Говьсүмбэр аймагт хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна гэжээ.

Эндээс манай улсад үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр нь гэр бүлийн хүчирхийлэл байгаа нь ажиглагдаж байна.



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

Гэр бүлийн хүчирхийлэл нь Үндсэн хууль (1992)-иар хамгаалагдсан хувь хүний хэд хэдэн үндсэн эрх, түүний дотор халдашгүй чөлөөтэй байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, цаашлаад хүний амьд явах эрхэд халддаг нийгмийн сөрөг үзэгдэл юм. Хүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл үйлдэл нь аливаа хэлбэрийн хүчирхийлэл бөгөөд тэдгээрээс хамгийн ноцтой нь төрөл, садны холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгддэг хүчирхийлэл мөн болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, түүнтэй тэмцэх арга замыг идэвхтэй эрэлхийлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүчирхийлэл үйлдэгч хохирогчтой нэг гэрт амьдардаг эсэхээс үл хамааран эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалzan дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн болон тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг ойр дотнын харилцаан хамааралтай хүмүүсийн хооронд үйлдэгддэг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)-ийн 3 дугаар зүйл зааснаар гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд, эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалzan дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүүгээс үйлдсэн хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийлэлд хамаарч, Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх эрх зүйн боломжтой болсон.

Олон улсад хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөх эрсдэлтэй, өртсөн иргэдийг тодорхойлох, хамгаалах, туслах, тэдгээр иргэдийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн интервенц боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн Эмзэг байдлыг

тодорхойлох загвар (DVM)-ыг ашигладаг. Энэхүү загварт тулгуурлан эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөд бүтцийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг тоон судалгаанд тулгуурлан боловсруулахыг зорилоо.

Аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хохирогчид шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэхийн тулд тухайн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, хүчин зүйлсийг тогтоох нь хамгийн чухал.

Гэр бүлийн хүчирхийлэл дэлхийн улс орнуудад түгээмэл тохиолддог бөгөөд илрэх хэлбэр, үйлдэгдэх арга нь янз бүр байдаг. Хэдийгээр өөр өөр улс орнууд өөр өөр гэмт үйлдлийн шалтгаантай тулгардаг боловч үндсэн шалтгаан нь дэлхий даяар ижил байсаар байгааг Австрийн Хүний эрхийн карьер (Австрийн Хүний эрхийн карьер, 2021)-н судалгаанд дурдсан байна. Мөн уг судалгаанд “гэр бүлийн хүчирхийлийг эмэгтэйчүүд тэвчдэгтүй гэж үздэг ч дэлхий даяар эмэгтэйчүүдийн 1/4 нь л гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн талаараа мэдээлж байдаг” гэжээ. Мөн судалгаанд эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүчин зүйлийг эдийн застийн хязгаарлагдмал байдал ба хөдөлмөр эрхлэлтийн тэгш бус байдал; боловсролын хүртээмжгүй байдал болон бусад (Шашин, улс төр, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах гэх мэт) хүчин зүйлтэй хамааруулан авч үзжээ.

НҮБ-ын Хүн амын сан, YCX-той хамтран хийсэн Жендерт суурилсан хүчирхийлийн тархалтын судалгаагаар хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 3 нь хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэн нэгэнд хэлдэгтгүй болох нь тогтоогджээ (Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан, 2017). Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь нь ямар ч нөхцөлд нөхөртөө эсхүл хамтран амьдрагч эрэгтэйдээ захирагдана гэдгийг хүлээн зөвшөөрсөн, ямар ч нөхцөлд нөхөр нь эхнэрээ зодож болно гэдэгтэй санал нийлсэн буюу хүчирхийлийг хүлцэн тэвчих хандлагатай нь холбоотой байна (Дэлхийн банк, 2024).

Гэр бүлийн хүчирхийллийн виктимиологи судалгааны тайланда дурдсанаар гэмт хэрэгт хохирсон боловч тэр даруйдаа хуулийн байгууллагад хандаагүй хүмүүсийн 73.2% нь ямар нэгэн объектив, субъектив шалтгаанаас болж хуулийн байгууллагад хандаагүй байна. Эдгээр хүмүүсийн 31% нь хэрэг сунжрахаас төвөгшөөсөн, 37.6% нь хуулийн байгууллагын хүнд суртлаас, 9.7% нь ичиж зовсон буюу нэр төрөө бодсон, 29.9% нь ямар нэгэн үр дүн гарагчийг тэж итгэсэн, 14.6% нь хүчирхийлэл үйлдэгчийн ёс хонзон, дарамтаас айсан гэж тайлбарлажээ (Ч.Нямсүрэн нар, 2023).

Эндээс харвал эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ч түүнийгээ мэдээлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах талаар хандахгүй байгаа нь хүчирхийллийг хүлцэн тэвчих хандлагатай, хүчирхийлэл үйлдэгчээс ирэх аюул заналаас айсан, хуулийн байгууллагад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байна гэж дүгнэж байна.

Ийм учраас гэмт хэрэгт хохирох явдлын шалтгаан болж, түүний нөхцөлийг бүрдүүлж, нөлөөлж байгаа объектив, субъектив хүчин зүйлүүдийг нарийвчлан тодорхойлох нь зүйтэй юм.

*Эдийн засгийн хязгаарлагдмал байдал ба хөдөлмөр эрхлэлтийн тэгши бус байдал*

Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банктай хамтран Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны үр дүнд үндэслэн ядуурлын түвшинг тогтоох судалгааг хийжээ. Уг судалгаан дахь ядуурлын тооцооны үр дүнг авч үзвэл, Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувь, 2022 онд 27.1 хувь болж, 2016 оны түвшнээс 2.5 хувь, 2020 оны түвшнээс 0.7 хувиар буурчээ (Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын ядуурлын түвшин, 2022).

Судалгаанаас харвал 2016 оноос хойш ядуурлын түвшин хот, хөдөөд аль алинд нь буурсан боловч ч хот суурин газрын хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэнд амьдарч буй ядуу хүн амын эзлэх хувь 2022 онд 64 хувь

болж тасралтгүй өсчээ (Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын ядуурлын түвшин, 2022).

Цагдаагийн байгууллагын мэдээллээр улсын хэмжээнд 2023 онд 35574 гэмт хэрэг бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1415 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 314 хэргээр буюу 18.2 хувиар буурч, бүх хэрэгт эзлэх хувийн жин 4.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.8 нэгжээр буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн 51.0 хувь нь Улаанбаатар хотод, 49.0 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ. Харин Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2023 онд 126 бүртгэгдсэн нь өмнөх оноос 28 хэрэг буюу 28.6 хувиар өссөн дүнтэй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 1459 иргэний 1282 буюу 87.9 хувь нь эмэгтэй, 170 буюу 11.7 хувь нь хүүхэд эзэлж байна. Нийт хохирсон эмэгтэйчүүдийн 611 буюу 47.6 хувь ажилгүй иргэд байна. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шалгагдсан 1334 хүний 636 буюу 47.6 хувь нь ажилгүй байна.

Үүнээс үзвэл эрхэлсэн тодорхой ажилгүй, ядуу өрхийн дунд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэргийн гаралт өндөр байгаа нь харагдаж байна.

*Боловсролын хүртээмжгүй байдал*

Боловсролын олон улсын ангилал (ISCED)-д тодорхойлсноор боловсрол нь хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн, урьдчилан нарийвчилж төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаанаас бүрдэнэ. Боловсролын үйл ажиллагаа нь эрдэм мэдлэг (learning) олгоход чиглэсэн зохион байгуулалттай, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоо (communication) юм.

Боловсролын ерөнхий хууль (2023)-д зааснаар боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд



МОНГОЛ УЛСЫН  
ХАДААГААРЛАНДАА  
ХОХИРСОН  
ДАРААГААРЛАНДАА



ХУУЛЬ САХИУЛАХАЙ

оршино гээд боловсролын үндсэн зарчим нь үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэг чиг хандлагад тулгуурлах; тогтвортой, уялдаатай, уян хатан байх; тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх; төр, олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай байх; насан туршийн суралцахуйг дэмжсэн байх; мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн байх; улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байхад чиглэгдэнэ хэмээжээ.

Үндэсний статистикийн хорооны 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээс харвал нийт хүн амын 64.9 хувь, эмэгтэй хүн амын 60.2 хувь, эрэгтэй хүн амын 69.9 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой нь харагдаж байна (Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны улсын тооллого-2020, 2021). Цагдаагийн байгууллагын мэдээлсэнээр 2023 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж шалгагдсан 1334 хүний 1029 буюу 77.1 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна гэжээ.

Үүнээс үзвэл хувь хүний боловсролын түвшин “бага” байх тусам хүчирхийлэл үйлдэх болон хүчирхийлэлд өртөх магадлал өндөр байна.

**Эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй бусад хүчин зүйл:**

Зарим төрлийн гэмт хэрэгт ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хохирогчийн яс үндэс, орон нутгийн зан заншлын уламжлал нь гэмт хэрэг виктимологийн ач холбогдолтой байхыг үгүйсгэж болохгүй юм.

Мөн “Шашин нь нэг талаас хүмүүст дуулгавартай ноомой байдлыг, нөгөө талаас энгийн даруу амьдарч хэрэглэхийг номлодог ч энэ нь зарим тохиолдолд хүч хэрэглэх, хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж байна” (Ч.Нямсүрэн нар, 2023) гэж эрдэмтэд үздэг бөгөөд Монгол Улсын хүн амын 4 гаруй хувийг Мусулман шашинтай Казак үндэстэн эзэлдэг

(Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны улсын тооллого-2020, 2021) тул анхаарч үзэх асуудлын нэг болж байна.

Хэдийгээр хууль сахиулах байгууллагын мэдээллээр шашиш шүтлэгтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргийн статистикийн мэдээлэл байхгүй ч энэ нь үүнтэй холбоогүй гэсэн үг биш юм.

Манай улсад энэ талаар хийгдсэн гэр бүлийн хүчирхийллийн судалгаа одоог хүртэл байхгүй үндэсний цөөнхийн дунд нуугдмал оршиж байгааг угүйсгэх аргагүй юм. Эдгээр хүмүүст нийгмийн, түүний дотор гэмт хэрэгтнээс хамгаалах хамгаалалт байнга дутагдаж байгааг дурдах нь зүйтэй.

### Дүгнэлт, санал

Улсын Их Хурлаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг зөрчил, гэмт хэрэгт тооцон хуульчилж, энэ төрлийн гэмт хэрэгтэй урьдчилан сэргийлэх цогц хууль тогтоомжийг мөрдөж, баагүй хугацаа өнгөрч байна.

Эрдэмтэн судлаачдын дунд тухайн төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, зөрчил, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдсан асуудал, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлын талаарх судалгаа шинжилгээний ажил цөөнгүй хийжээ.

Гэвч эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл буурахгүй, хүчирхийлэлд өртөх эрсдэл байсаар байгааг боловч энэ чиглэлээр хийсэн судалгааны ажил хомс байгааг дээр дурдсан.

Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох замаар энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх виктимологийн арга замыг тодорхойлох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Иймд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч буй зарим хүчин зүйлийг саармагжуулах чиглэлээр



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

дараах арга хэмжээг санал болгож байна.  
Үүнд:

- ✓ Эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх хүчин зүйлсийг тоон болон чанарын судалгаанд тулгуурлан гүнзгийрүүлэн тодорхойлох;
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр үндэсний дунд хугацааны хөтөлбөр боловсруулах;
- ✓ Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад гэр бүлийн тухай ойлголт, гэр бүлийн харилцаа, үүрэг хариуцлага, хүчирхийллийн талаарх ойлголт тусгасан эсэхийг судалж дүн шинжилгээ хийх замаар цаашид “Гэр бүлийн боловсрол” олгох цогц хөтөлбөр боловсруулах;
- ✓ Бүрэн дундаас доош боловсролтой эмэгтэйчүүдийг мэргэжил олгох хөтөлбөрт хамруулж, жижиг болон өрхийн бизнес эрхлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ажлын байранд зуучлах, байнгын ажлын байраар хангах санал боловсруулах;
- ✓ Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийн талаарх суурь судалгааг хийж, судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх зэрэг болно.

#### **Ашигласан материал**

Монгол Улсын Их Хурал. (1992). *Үндсэн хууль*. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2023).

*Боловсролын ерөнхий хууль.*  
Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2016). *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль*. Улаанбаатар.

Human Rights Careers. (2021). Austria's human rights career. Retrieved from <https://www.humanrightscareers.com>

ГХУСАЗЗАА, Хөгжлийн эрх зүйн төв ТББ. (2023). *Гэр бүлийн хүчирхийллийн судлагдсан байдлын тойм*. Улаанбаатар.

Дэлхийн банк. (2024). Монгол Улс дахь жендерийн нөхцөл байдлын үнэлгээ.

Жанцан, С. (1996). *Хохирогч судлал, түүнийг нөлөөллөөс хамгаалах асуудал*. Монголын төр, эрх зүй.

Үндэсний статистикийн хороо. (2021). *Хүн ам, орон сууцны улсын тооллого-2020*. Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо. (2022). *Монгол Улсын ядуурлын түвшин*. Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан. (2017). *Жендерт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаа*. Улаанбаатар.

Нямсүрэн, Ч. (2005). *Гэмт хэргийн виктимологи*. Улаанбаатар.

Нямсүрэн, Ч., & бусад. (2023). *Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн виктимологи*. Улаанбаатар.